



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 14 өдөр

Дугаар А/68

Ховд


Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 05/07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Жаргалант сумын Ерөнхий боловсролын Прогресс сургуулийн багш нарыг элсэлтийн ерөнхий шалгалт, чанарын үнэлгээгээр тогтмол амжилттай яваа Эрдэнэт, Дархан хотын сургуулиудын багшийн хөгжил, арга зүйн туршлагаас суралцах арга хэмжээний замын зардалд 3 360 000 төгрөгийг баталж, зарцуулсугай.

2. Зардалд зарцуулагдах 3 360 000 төгрөг /гурван сая гурван зуун жаран мянга/-ийг 2022 оны аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний жагсаалтын 4.2 дахь “Боловсролын салбарын дэд хөтөлбөрүүд /Чадварлаг багш, оюутан, сурагч/” хөтөлбөр, төслөөс тооцож гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга /Б.Баярсүх/ нарт зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн аймгийн Засаг даргын орлогч /Т.Дэлгэрсайхан/-д даалгасугай.



ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

8400 01 0330

Zah A/68 Kh